ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ

ЗУРАГ ТӨСЛИЙН БАРИМТ БИЧГИЙН

# МАГАДЛАЛЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

2018 оны 05-р сарын 14 өдөр Дугаар 40/2018

Улаанбаатар-16100
Утас: 70001150
Факс: 70007636

| | |
|---|---|
| **Обьектын нэр:** | Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 2-р хороо, Чингисийн өргөн чөлөөнөөс Мишээл худалдааны төвийн зүүн талаар Туул голын гудамж хүртэлх авто замын зураг төсөл, шифр: 01/17 |
| **Обьектын байршил:** | Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 2-р хороо |
| **Хүчин чадал:** | 0.73 км |
| **Захиалагч:** | “Мишээл групп” ХХК |
| **Санхүүжмлтийн эх үүсвэр:** | Нийслэлийн хөрөнгө оруулалт |
| **Зураг төслийн ерөнхий гүйцэтгэгчийн нэр** | “Даваа зам” ХХК |
| **Регистрийн дугаар:** | 5072581 |
| **Тусгай зөвшөөрлийн хүчинтэй байх хугацаа:** | 2017.10.14 Зам, тээврийн хөгжлийн яамны 2018 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн 06/283 тоот албан бичгийг хавсаргав. |
| **Зураг төсөл боловсруулах үндэслэл:** | |
| Газар эзэмшүүлэх, ашиглуулах эрх, олгосон захирамж, дугаар огноо: | Нийслэлийн Засаг даргын 2017 оны 7 дугаар сарын 17-ны өдрийн А/543 дугаар захирамжаар газар эзэмших эрх олгосон. |
| Зураг төсөл боловсруулах даалгавар, баталсан албан тушаалтан, дугаар, огноо: | Нийслэлийн Засаг даргын дэд бүтэц, гэр хорооллын хөгжлийн асуудал хариуцсан орлогчоор батлагдсан авто замын зураг төсөл боловсруулах ажлын даалгавар, №ЗД-17/028 |
| Зураг төслийн гэрээ, баталсан албан тушаалтан, дугаар, огноо: | “Мишээл групп” ХХК болон “Даваа зам” ХХК-ны хооронд 2017 оны 3 дугаар сарын 24-ны өдөр байгуулсан зураг төсөл боловсруулах гэрээ |

**Техникийн нөхцлүүд:**

| Техникийн нөхцлүүд | Олгосон байгууллага | Дугаар, огноо | Хүчинтэй байх хугацаа |
|---|---|---|---|
| | | | |

**Зөвшөөрөлцсөн байгууллага:**

| | |
|---|---|
| Улаанбаатар хотын ерөнхий архитектор бөгөөд Нийслэлийн хот байгуулалт, ерөнхий төлөвлөгөөний газрын дарга | Э.Анар |
| Нийслэлийн Авто замын хөгжлийн газрын Бодлого, зохицуулалтын хэлтсийн дарга | Ж.Даваасүрэн |
| Нийслэлийн газрын албаны дарга | Э.Болорчулуун |
| Ус сувгийн удирдах газрын ерөнхий инженер | Ж.Дагвадорж |
| “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-ны ерөнхий инженер | Б.Батбаяр |
| Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ны дэд захирал | Р.Дагдан |
| “Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨХК-ны ерөнхий инженер | Н.Наранбаатар |
| Геодези, усны барилга байгууламжийн газрын дарга | Т.Цэрэнноров |

**Зураг төслийн бүрэлдэхүүн:**

| Зургийн бүрдэл: | Зураг төслийг гүйцэтгэсэн байгууллагын нэр: | Шалгасан экспертийн нэр: |
|---|---|---|
| Авто замын инженерийн нарийвчилсан зураг<br>Техникийн шаардлага | “Даваа зам” ХХК | С.Очирбат |

| | | |
|---|---|---|
| Тайлбар бичиг | | |
| Авто замын төсөв | | Л.Баасанбат |
| Геологийн судалгааны ажлын тайлан | “Лэнд тест” ХХК Архивын материал №17/100 | Ч.Баатар |
| Геодезийн тайлан | “Эрхт газар инженеринг” ХХК | - |
| **Ерөнхий дүгнэлт:** | | |

| | |
|---|---|
| Зам, замын байгууламжийн чигийн сонголт болон техник-эдийн засгийн үзүүлэлтүүд, зураг төслийн үндсэн төлөвлөлт, шийдэл, хучилтын бүтээцийн талаарх дүгнэлт | **Барилга байгууламжийн төлөвлөлт, хүчин чадал:**<br>Замын урт 0.73 км, далангийн өргөн 18.4 м, зорчих хэсгийн өргөн 2х7.0 м, ногоон байгууламж 2х0.5 м, явган зам 2х1.2 м, хөвөө 2х0.5 м байхаар төлөвлөсөн байна.<br>**Авто замын хучилтын хийц:**<br>Өнгө асфальтбетон хучилт 30 мм<br>Суурь асфальтбетон хучилт 40 мм<br>Буталсан чулуун суурь 200 мм<br>Хөлдөлтөөс хамгаалах үе 300 мм |
| Боловсруулсан зураг төслийн сонгосон шийдэл, магадлалын ажлын явцад хийсэн нэмэлт, өөрчлөлтөөс шалтгаалах үр дүнгийн талаарх тодорхой санал, дүгнэлт: | Орон тооны бус экспертийн дүгнэлтийн дагуу зураг төсөлд холбогдох засвар, өөрчлөлтүүдийг оруулж, дахин хянуулан баталгаажуулсан байна. Үүнд:<br><u>Зураг төсөлд:</u><br>Авто замын зураг төсөлд /2018 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн дүгнэлт/<br><u>Төсөвт өртөгт:</u><br>Авто зам, гүүрийн төсөвт өртгийн тооцоонд /2018 оны 5 дугаар сарын 04-ний өдрийн дүгнэлт/<br>Дээрх дүгнэлтүүд нь магадлалын ерөнхий дүгнэлтийн хавсралт болно. |
| Зураг төслийн талаар явуулж байгаа төрийн нэгдсэн бодлого, хууль тогтоомж, норм нормативын баримт бичгийг үндэслэн боловсруулсан төслийн сонгосон шийдэл, төслийг хэрэгжүүлснээр гарах үр дүнгийн талаарх тодорхой санал, дүгнэлт | Зураг төслийг хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа норм, дүрмүүдийг баримтлан боловсруулсан байна. Үүнд:<br>-“Авто зам төсөллөх” ЗЗБНбД 22-004 -2016<br>-“Хот суурины гудамж, зам төлөвлөлт” БНбД 32-01-04<br>-“Авто замын гүүр ба хоолой төсөллөх” БНбД 32-02-12<br>-Зам, тээвэр, барилга хот байгуулалтын Сайдын 2011 оны 7 дугаар сарын 18-ны өдрийн 200 дугаар тушаалаар батлагдсан “Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсөв зохиох заавар”<br>-“Авто замын барилгын төсвийн жишиг норм” БНбД 81-25-07<br>-“Төмөрбетон гүүр, хоолойн барилгын төсвийн жишиг норм” БНбД 81-28-07<br>-Замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага MNS 4596:2014<br>-Замын тэмдэглэл. Техникийн ерөнхий шаардлага MNS 4759:2014<br>-“Авто замын уур амьсгал, геотехникийн нөхцөл” АЗУАГН 2.01.01-2004 болон бусад норм, дүрмүүд. |
| Эдийн засгийн үр ашиг, хөдөлгөөний аюулгүй байдал, экологийн хор хөнөөлгүй байдал, ашиглалтын үеийн найдвартай ажиллагаа, төсөвт өртгийн тооцооны талаарх дүгнэлт | Төсвийг орон тооны бус экспертүүд дараах байдлаар хянаж баталгаажуулсан байна. Үүнд:<br>0.73 км авто замын барилгын ажил **1 059 060 205** төгрөг<br>Ус зайлуулах байгууламжийн ажил **514 695 059** төгрөг<br>Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 2-р хороо, Чингисийн өргөн чөлөөнөөс Мишээл худалдааны төвийн зүүн талаар Туул голын гудамж хүртэлх авто замын барилгын ажлын төсөвт өртгийг нийт **1 573 755 264** төгрөг байхаар хянаж баталгаажуулсан байна.<br>Төсвийн нийт тооцоо, иж бүрдлийг хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа үнэ бүрдлийн норм, нормативын дагуу тооцсон болохыг хянаж, дүгнэв. |

**“Авто замын тухай” хуулийн 19.4, 19.5-д тус тус заасны дагуу Авто зам, замын байгууламжийн зураг төслийн алдааг зураг төсөл боловсруулсан байгууллага, зохиогч хариуцах ба зураг төслийн техникийн шийдлийн талаар гаргасан дүгнэлтийн алдааг магадлал хийсэн этгээд хариуцна.”**

Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 2-р хороо, Чингисийн өргөн чөлөөнөөс Мишээл худалдааны төвийн зүүн талаар Туул голын гудамж хүртэлх 0.73 км авто замын зураг төслийн баримт бичгийг холбогдох нормуудын шаардлагад нийцүүлэн төлөвлөсөн бөгөөд уг зураг төслөөр зам барилгын ажил гүйцэтгэх боломжтой гэж дүгнэж байна.

Тус зураг төслийн ажилд “Зам, замын байгууламжийн зураг төсөлд магадлал хийх үйл ажиллагаа зохион байгуулах журам”-ын дагуу магадлалын ерөнхий дүгнэлт бичсэн болно.

Магадлалын ерөнхий дүгнэлт нь орон тооны бус экспертүүдийн гаргасан дүгнэлтийн хамт хүчинтэй. (Хавсралт: 8 хуудас)

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН ЗАХИРАЛ — Р.БУД

ЗУРАГ ТӨСЛИЙН МАГАДЛАЛ, СТАНДАРТ, НОРМ, НОРМАТИВЫН ХЭЛТСИЙН ДАРГА — Д.САРАНДУЛАМ

5645313 1115202769

ЗУРАГ ТӨСЛИЙН МАГАДЛАЛ, СТАНДАРТ, НОРМ НОРМАТИВЫН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН — С.МӨНХТУЯА

**АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛД МАГАДЛАЛ ХИЙХ ЭКСПЕРТИЙН ДҮГНЭЛТ, МАГАДЛАЛЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ.**

ХАВСРАЛТ №1

Зураг төслийн бүрдлийн хэсгийн нэр, марк, хуудасны тоо

**“Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 2-р хороо, Чингэсийн өргөн чөлөөнөөс Мишээл худалдааны төвийн зүүн талаар Туул голын гудамж хүртэлх авто замын зураг төсөл”**

2018 оны 04 сарын 17 өдөр

| Д/д | Утга | Тайлбар |
|---|---|---|
| 1 | Обьектийн нэр | *“Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 2-р хороо, Чингэсийн өргөн чөлөөнөөс Мишээл худалдааны төвийн зүүн талаар Туул голын гудамж хүртэлх авто замын зураг төсөл”* |
| | | 730.1 м |
| 2 | Обьектийн байршил, хүчин чадал | “Даваа зам” ХХК |
| 3 | Зураг төслийн байгууллага | |
| 3.Дүгнэлтийн товч утга:/МУЗГ-ын 2009 оны 204 дүгээр тогтоолын 7-р зүйлээс/ | | |
| 4 | 7.5.1. барилга байгууламжийн байршил тогтоосон шийдвэр, архитектур төлөвлөлтийн болон зураг төсөл боловсруулах даалгавар, эх загвар зураг, байгаль, цаг уурын ерөнхий өгөгдлүүд, техникийн нөхцөл, холбогдох мэргэжлийн байгууллагатай зөвшилцсөн байдал | УБ хотын ерөнхий архитектор бөгөөд Нийслэлийн хот байгуулалт, ерөнхий төлөвлөгөөний газар, НАЗХ Газар, Нийслэлийн газрын алба, Ус сувгийг удирдах газар, “УБ хотын дулааны сүлжээ” ТӨХК, “УБ хотын цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК, “Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨХК болон Геодези, |

| | | |
|---|---|---|
| | | усны барилга байгууламжийн газруудтай зөвшилцсөн. |
| 5 | 7.5.2. барилга, байгууламжийн архитектур төлөвлөлт, бүтээц, инженерийн хангамжийн шийдэл нь дагаж мөрдөж байгаа норм, дүрэм, стандарт, технологийн даалгавар,тоног төхөөрөмжийн пасспорт, инженер-геологийн судалгааны дүгнэлт,техникийн нөхцөлийн дагуу зохиогдсон эсэх | *"Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 2-р хороо, Чингэсийн өргөн чөлөөнөөс Мишээл худалдааны төвийн зүүн талаар Туул голын гудамж хүртэлх авто замын зураг төсөл" 730*,1м замын зураг нь өнөөгийн мөрдөж байгаа БНбД, Техникийн шаардлага, стандарт, болон замын инженер-геологийн судалгааны дүгнэлт,техникийн нөхцөлийн дагуу зохиогдсон байна. |
| 6 | 7.5.3. барилга байгууламжийн байршил, хот төлөвлөлт, инженер-геологийн нөхцөл, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл,сонгосон байршил, талбайн инженерийн хангамжийн хувилбар, харьцуулсан тооцоо, сонгосон хувилбарын талаарх дүгнэлт | *"Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 2-р хороо, Чингэсийн өргөн чөлөөнөөс Мишээл худалдааны төвийн зүүн талаар Туул голын гудамж хүртэлх авто замын зураг төсөл"* авто замын зураг нь тухайн замын инженерийн шийдлүүдийг болон замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангасан байна. |
| 7 | 7.5.4. зураг төслийн төлөвлөлт, техникийн шийдэл нь материал, түлш, эрчим хүч, усны нөөцийг хэмнэлттэй ашиглах нөхцлийг бүрдүүлсэн байдал | *"Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 2-р хороо, Чингэсийн өргөн чөлөөнөөс Мишээл худалдааны төвийн зүүн талаар Туул голын гудамж хүртэлх авто замын зураг төсөл"* нь зам барилгын өртгийг хамгийн бага байлгах нөхцөлийг хангасан гэж үзэв. |
| 8 | 7.5.5. хөдөлмөр хамгаалал, техникийн аюулгүй ажиллагаа, орчны эрүүл ахуйг байдалд тавигдах стандартын шаардлага болон норм, дүрмийг баримталсан байдал | Ажлын нарийвчилсан зураг нь зам барилгын ажлын явцад тухайн гүйцэтгэгчийн хөдөлмөр хамгаалал, техникийн аюулгүй ажиллагаатай нэг их холбоогүй ч гэсэн энэ асуудалд сөрөг нөлөөгүй байна. |
| 9 | 7.5.6. хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажиллаж, амьдрах нөхцлийг хангасан төлөвлөлтийн шийдлийг тусгасан байдал | Ажлын нарийвчилсан зураг нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажиллаж, амьдрах нөхцлийг хангах асуудалтай уялдсан гэж |

| | | |
|---|---|---|
| | | үзэв. |
| 10 | 7.5.7. хөрсний бохирдлоос хүрээлэн байгаа орчныг хамгаалах, үйлдвэрийн бохирдсон усыг цэвэрлэж ашиглах боломж, гадагш хаяж байгаа бохирдсон агаар, ус норматив үзүүлэлтийг хангаж буй эсэх | *"Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 2-р хороо, Чингэсийн өргөн чөлөөнөөс Мишээл худалдааны төвийн зүүн талаар Туул голын гудамж хүртэлх авто замын зураг төсөл"* нь замын орчны болон замын гадаргын ус зайлуулах асуудлыг бүрэн шийдсэний зэрэгцээ үер, борооны үед зам руу орчноос урсан ирэх усны урсгалын асуудлыг бүрэн шийдсэн бөгөөд хөрсний бохирдол, хүрээлэн буй орчныг хамгаалах асуудалтай зохицсон байна. Энэхүү зам нь үйлдвэрийн бохирдсон устай холбоогүй юм. |
| 11 | 7.5.8. инженерийн шугам сүлжээний уртын дагуух төлөвлөлтийн оновчтой шийдэл | Энэ нь орчны инженерийн шугам сүлжээтэй уялдсан бөгөөд холбогдох зөвшилцлүүдийг хиийсэн байна. |
| 12 | 7.5.9. барилга байгууламжийн гаднах ерөнхий төрх, архитектурыг хот төлөвлөлтийн шаардлагад нийцүүлэн орчны барилга байгууламжтай уялдуулсан байдал, ээлхүүн болон талбайг үр ашигтай төлөвлөсөн байдал | *"Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 2-р хороо, Чингэсийн өргөн чөлөөнөөс Мишээл худалдааны төвийн зүүн талаар Туул голын гудамж хүртэлх авто замын зураг төсөл"* нь хүрээлэн буй орчинтой нягт уялдан төсөллөгдсөн. |
| 13 | 7.5.10. барилгын ажлын зохион байгуулалтын болон барилга байгууламжийг буулгах, задлах ажил гүйцэтгэх зураг төсөлд хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны шаардлагыг тусгасан байдал | *"Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 2-р хороо, Чингэсийн өргөн чөлөөнөөс Мишээл худалдааны төвийн зүүн талаар Туул голын гудамж хүртэлх авто замын зураг төсөл"-д* энэ асуудал хамаарахгүй. |
| 14 | 7.6. магадлалын дүгнэлтэд хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийг үндэслэн төлөвлөлт, техникийн үндсэн шийдэл, эдийн засгийн үр ашигт мэргэжлийн үнэлэлт өгч, техник-эдийн засгийн үндэслэл, зураг төсөлд нэмж тусгах буюу хасах, өөрчлөх асуудлын талаар товч, тодорхой тусгана. | *"Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 2-р хороо, Чингэсийн өргөн чөлөөнөөс Мишээл худалдааны төвийн зүүн талаар Туул голын гудамж хүртэлх авто замын зураг төсөл"*–т дүгнэлт өгч өөрчлөлт, засвар хийх заавар өгсөн бөгөөд үүний дагуу зургын байгууллага нь зохих засварыг хийж, зарим тайлбаруудыг өгсөн |

| | | |
|---|---|---|
| | | нь хангалттай гэж үзэж байна. |

Дүгнэлт бичсэн:

Эксперт, Содын Очирбат /овог нэр/ /гарын үсэг/

MONGOLIA S. OCHIRBAT CONSULTANT ENGINEER 97 106

2018 оны 04 сарын 17-ны өдөр

Зураг төслийн баримт бичгийн
МАГАДЛАЛЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТИЙН ХАВСРАЛТ №2

ЗУРАГ ТӨСЛИЙН БҮРДЛИЙН ХЭСГИЙН НЭР:

**"Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 2-р хороо, Чингэсийн өргөн чөлөөнөөс Мишээл худалдааны төвийн зүүн талаар Туул голын гудамж хүртэлх авто замын зураг төсөл"**

*2018 оны 4 сарын 16-ны өдөр*

| Д/д | Утга | Тайлбар |
|---|---|---|
| 1 | **Обьектийн нэр** | *"Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 2-р хороо, Чингэсийн өргөн чөлөөнөөс Мишээл худалдааны төвийн зүүн талаар Туул голын гудамж хүртэлх авто замын зураг төсөл"* |
| 2 | **Обьектийн байршил, хүчин чадал** | *"Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 2-р хороо, ПК0+00-7+30,1* |
| 3 | **Зураг төслийн байгууллага** | *"Даваа зам" ХХК* |

| Д/д | Экспертийн санал, илэрсэн алдаа зөрчил | Алдаа, зөрчлийг засаж, төсөлд засвар оруулсан тухай тайлбар, танилцуулга |
|---|---|---|
| **Ажлын даалгавараас дутуу хийсэн зүйлүүд** | 1. Ажлын даалгаварын онцгой нөхцөлд өгөгдсөн "...зам барих үед геометр хэмжээг хангах хэмжилтийн төсөл даалгвар боловсруулах. Геодезийн хяналтын инженерээр хянуулж баталгаажуулах" гэсэн зүйлийг хэрхэн гүйцэтгэсэн нь тодорхойгүй байна.<br>2. "Гадаргуугийн ус зайлуулалтыг ус хураах талбайн хэмжээнд тооцоо хийж төлөвлөх" гэсэн заалтын дагуу хийсэн зүйл харагдахгүй байна.<br>3. Уулзвар, аюулгүйн тойрог, хөдөлгөөн зохион байгуулалтыг цогц шийдвэрлэх. Замын хөдөлгөөний удирдлагын төвтэй зөвшилцөх" гэсэн байгаа боловч хийгдээгүй байна.<br>4. "...орчны тоймыг 3D зураг ..." гэсэн байгаа боловч үүнийг олж харсангүй. | *1) Зам барилгын дараах гүйцэтгэлийн зурагтай хамаатай учир уг зураг төсөлд хамаарахгүй<br>2)Гадаргуун ус зайлуулалтыг ус хураах талбайн хэмжээнд тооцон урсан өнгөрөх зарцуулгыг ГУББГ ОНӨААТҮГ-тай зөвшилцөн хянуулсан.<br>3)BRT төсөл Чингисийн өргөн чөлөөгөөр хийгдэх гэж байгаа тул тус уулзвар уг төслийн хүрээнд бүрэн шинэчлэл хийгдэнэ гэж үзсэн бөгөөд ЗХУТ-тэй зөвшилцсөн.* |

| | | |
|---|---|---|
| | | *4)Захиалагчийн зүгээс 3D зураг хэрэггүй гэж үзсэн.* |
| **Тайлбар бичиг** | 1. Тайлбар бичиг дотор "Төслийг боловсруулахад оролцсон компаниуд" гэсэн зүйл дотор "Гэрэлтүүлэг болон гадна цахилгаан" хийсэн компанийн нэр байхгүй байна. | *1)Тайлбар бичигт Гэрэлтүүлгийн компанийн нэрийг орхигдуулсан байсныг оруулсан. (**Тайлбар бичгийн Ху-1**)* |
| | 2. "Зураг 3. Хучилтын тооцооны үр дүнгүүд" гэсэн хүснэгтэд "...хадан хөрс..." гэж орсоныг засах. | *2)Хучилтын тооцооны үр дүнгийн хүснэгтэд "хадан хөрс" гэж орсныг "хадан материал" гэж засварласан. (**Тайлбар бичиг Ху-10**)* |
| **Дэвсгэр зураг** | 1. Зураг дээр байгаа "Дулааны шугамын төмөр шон"-г зайлуулах, үлдээх бол Замын цагдаа болон Хөдөлгөөний удирдах төвтэй зөвшилцөх.<br>2. Мишээл экспогоос гарч баруун гар тийш эргэж байгаа замын эргэлтийн радиус 5,2 м, түүний эсрэг байгаа баруун гарын эргэлтийн радиус 4,0 м, Мишээл экспо руу орж байгаа орц 7,5 м радиустай гэж ойлгогдож байна. Хотын хуримтлуулах зориулалтын гудамж замын төсөллөлтөд "гурван тэнхлэгт ачааны машин"-г тооцоот тээврийн хэрэгслээр авдаг тул эргэлтийн радиусыг тооцоот тээврийн хэрэгсэлд тохируулан авах ёстой. | *1) Дулааны 2ф800мм голчтой 10д магистраль төв шугамын шонг зайлуулах боломжгүй бөгөөд УБДС-ТӨХК-тай зөвшилцөн мөн ЗХУТөвтэй зөвшилцөн тус хэсэгт төмөр арам төлөвлөхөөр шийдвэрлэсэн. (**Бүлэг ХЗ-1 Ху-1**)<br>2)Тус орц гарцуудын эргэлтийн радиусуудыг засварлах 8м болгосон. (**Бүлэг ДЗ-6 Ху-3**)* |
| **Дагуу огтлол** | "Мишээл экспо төвийн орц гарц 2"-ийн дагуу налуу 22% байгаа нь хэт огцом болсон тул налууг багасгах. | *Тус орц гарц төлөвлөгдөө одоо больсон бөгөөд Тус дагуу огтлол дээрх налуугийн хэмжээ 22% биш 22промиль буюу 2.2% юм* |
| **Нэг маягийн хөндлөн огтлол** | Замын хөвөөний бэхэлгээний "г" хавтангийн хэмжээг 20,000 болон 500 гэж хоёр өөрөөр бичсэнийг залруулах. | *Нэг маягийн хөндлөн огтлол дээр 500мм өргөн бүхий L хашлагын хэмжээг 20000 гэж давхцуулж тавьсан хэмжээг залруулан 500мм болгосон.(**Бүлэг НМХО-1 Ху-1** )* |
| **Хучилт** | Хучилтын суурийг 20 см зузаан буталсан чулуугаар хийхээр тооцжээ. Тооцоогоор иймэрхүү гарч болно, гэхдээ "Мишээл экспо" нь цаашид энэ байдлаар үйл | *Тус хучилтын хийцийг тооцохдоо дээр дурдсан хөдөлгөөний эрчмийн* |

| | | |
|---|---|---|
| | ажиллагаа байнга явуулах бол хучилтын хийцийг хянан үзэх шаардлагатай байна. Үүнтэй уялдуулан хөдөлгөөний эрчмийн тооллого явуулах, даацын судалгаа хийх шаардлагатай. Мишээл экспо руу хүнд даацын тээврийн хэрэгсэл болон Төв аймгийн автобус байнга орж, гарч байна. Иймд суурийн материалыг бэхжүүлж, илүү даацтай болгох шаардлагатай харагдаж байна. | *тооллого даацын судалгаанд үндэслэн Индоркад програмыг ашиглан гүйцэтгэсэн.* |
| **Хөндлөн огтлол** | 1. Энэ замын хөдөлгөөний байдал ба эрчмийг дээр тайлбарласан. Нөгөө талаар энэ зам нь хуримтлуулах гудамж замын зэрэглэлд орж байгаа тул төсөллөлтийн нормын дагуу хөдөлгөөний зурвасын өргөнийг 3,5 метрээр авах ёстой байна.<br>2. Энэ зам нь “худалдааны төв”-ийн зам тул явган хүний замын өргөн хангалтгүй байна. | *1)Төлөвлөж буй авто замын Зурвасын өргөнийг 3,5м болгон засварласан.<br>2)Явган хүний замын өргөнийг явган хүний цагт өнгөрөх эрчим мөн авто замын ангиллаас хамааруулан хотын замын норм дүрмээс харан сонгосон. Мөн газар чөлөөлөлтийг бодолцсон. (**Бүлэг НМХО-1 Ху-1**)* |
| **Үзлэгийн худгийн хөндлөн огтлол** | Замын гадаргуугийн ус зайлуулах шугамд “ган хоолой” ашиглахаар төлөвлөжээ. Орчин үед ган хоолойг усны байгууламжид ашиглахаа больсон тул солих шаардлагатай. | *ГУБЕГ – ОНӨААТҮГ-н саналын дагуу ган хоолойг сонгосон төлөвлөсөн.* |

*Дүгнэлт бичиж, биелэлтийг шалгасан эксперт № Сод овогтой Очирбат /овог нэр/*
*2018 он 12 сар 14 өдөр*

MONGOLIA
Sod OCHIRBAT
CONSULTANT ENGINEER
97 106

*Гарын үсэг*

*Биелэлтийн тайлбар бичсэн Үнэнсанаа Эрдэнэсанаа ........................../овог нэр/*
*..............он..............сар............өдөр*

*Зураг төслийн баримт бичгийн*

МАГАДЛАЛЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТИЙН ХАВСРАЛТ №1

ЗУРАГ ТӨСЛИЙН БҮРДЛИЙН ХЭСГИЙН НЭР /ТӨСВИЙН ТООЦОО/

| д/д | Утга | Тайлбар |
|---|---|---|
| 1 | Объектийн байршил, хүчин чадал | Хан Уул дүүрэг, 2 хороо, Чингисийн өргөн чөлөөнөөс Мишээл худалдааны төвийн зүүн талаар Туул голын гудамж хүртэлх барилгын ажлын төсөв |
| 2 | Объектийн нэр, шифр | Хан Уул дүүрэг, 2 хороо, Чингисийн өргөн чөлөөнөөс Мишээл худалдааны төвийн зүүн талаар Туул голын гудамж хүртэлх барилгын ажлын төсөв |
| 3 | Объектийн бүрдлийн хэсгийн нэр, хуудасны тоо, гүйцэтгэсэн ААН байгуулага | Засварын ажил төсөв-1 дэвтэр, нийт 16 хуудас. Зураг төслийн байгууллага "Даваа зам" ХХК |
| 4 | Төсвийн тооцооны программ, төсвийн тооцоог хийсэн байгууллагын нэр, гүйцэтгэсэн инженер | ЗТБХБ-ын сайдын 2011 оны 7 дугаар сарын 18-ны өдрийн 200 дугаар тушаалаар батлагдсан "Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсөв зохиох заавар"-ын дагуу хийгдсэн комьютерийн RBC-Estimator программ ашиглан төсвийн тооцоог хийсэн байна. Зам барилгын ажлын төсвийг Мэргэшсэн төсөвчин Б.Энхтуяа хийж гүйцэтгэсэн байна. |
| 5 | Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын тоо хэмжээг үнэн зөв тодорхойлсон байдал | Төсөв зураг төслийн тоо хэмжээний дагуу зохиогдсон байна. Зургийн инженерийн тодорхойлсон тоо хэмжээг төсвийн тооцоонд хавсаргасан байна. |
| 6 | Төсвийн тооцоонд ашигласан норм, норматив, үнэ үнэлгээ | Төсвийн тооцоог БНбД 81-25-07, БНбД 81-26-08, БНбД 81-28-07 суурь жишиг нормуудаар үнэлсэн байна. |
| 7 | Төсвийн тооцооны арга, аргачлалын оновчтой байдал, төслөөр тодорхойлсон нөөцийг оновчтой ашигласан байдал | Төсвийн тооцооны иж бүрдэл хангагдсан байна. Холбогдох хууль, журмын дагуу зардлыг тооцож төсөв зохиосон тайлбарыг хавсаргасан байна. |
| 8 | Төсвийн тооцоо, түүний хэлбэржүүлэлтэд зайлшгүй оруулах шаардлагатай засвар, өөрчлөлт | -байхгүй |
| | *Дүгнэлтийн товч утга* | |
| 1 | Төсвийн тооцоо нь дагаж мөрдөж буй норм, дүрэм, стандартын дагуу оновчтой зохиогдсон эсэх | Төсвийн тооцоог дагаж мөрдөж буй норм, дүрэм, стандартын дагуу зохиогдсон байна. |

Дүгнэлт бичсэн:

Эксперт №12-03 Л.Баасанбат

2018 оны 05 дугаар сар 04-ний өдөр

Эксперт дүгнэлтийг компьютерээр 2 хувь бичиж, гарын үсэг, тамга тэмдгээ дарж баталгаажуулсан байна.